



ДУНДГОВЬ АЙМАГ  
АДААЦАГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 06 сарын 07 өдөр

Дугаар 1/53

Тавин

Газар эзэмшүүлэх эрхийн дуудлага  
худалдаа явуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.2 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Газрын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.2 дахь заалт, Засгийн газрын 2016 оны 10 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт, сумын 2023 оны "Газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөө"-г үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Адаацаг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 12 дугаар сарын 19-ны өдрийн 24 дүгээр тогтоолын дагуу Адаацаг сумын нутаг дэвсгэрт 1 байршлын 18000 м.кв (1.8 га) газрыг хавсралтад заасан зориулалтын дагуу газар эзэмших эрхийн дуудлага худалдааг цахимаар зохион байгуулсугай.

2. Дуудлага худалдааны зарчмаар эзэмшүүлэх газрын хэмжээ, зориулалт байршил, хугацаа, дуудлага худалдааны анхны үнэ, дуудлага худалдаа явуулах өдрийг хавсралтаар баталсугай.

3. Дуудлага худалдааг цахим хэлбэрээр явуулж, дуудлага худалдааны зар мэдээг [www.mle.mn](http://www.mle.mn) газрын цахим биржид болон мэдээллийн хэрэгслээр олон нийтэд нээлттэй зарлан явуулсугай.

4. Дуудлага худалдаа явуулах хугацаа, тавигдах шаардлага нөхцлүүдийг тодорхойлон олон нийтэд зарлан мэдэгдэж хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулахыг Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын, Газрын кадастрын асуудал хариуцсан мэргэжилтэн (Б.Батцэцэг)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ч.УРАНЧИМЭГ

4002010110